

Institute of General and Experimental Biology, Mongolian Academy of Sciences;

Commission on Marmots Investigation of the Theriological Society at the RAS
Mammalian Ecology Society of Mongolia;



Compilation of the I-VI International Marmot CONFERENCE PROCEEDINGS

ULAANBAATAR 2018

МОНГОЛЫН АМЬСЭНГИЙН АКАДЕМИ
| I-VI | МЭМЭГЭЙН ТЭРИОЛОГИ
АНД АМЬСЭНГИЙН ХИЙЛЭН
ТАВИАЛ

Compilation of the I-VI International Marmot Conference Proceedings, Ulaanbaatar,
Narud Design LLC, 2018, 188 pp.

Compilers: Adiya Yansanjav, Undrakhbayar Enkhbat



INTERNATIONAL CONFERENCE ON THE GENUS *MARMOTA*

Previous international conferences of marmot researchers

A history of international conferences on the Genus *Marmota*

Тарвага судлаачдын олон улсын хурлууд

Species of the genus *Marmota* are distributed across vast territories of Eurasia and North America and have high ecosystem and practical value. They have attracted the interest of scientists around the world, resulting in many research projects and a wide variety of publications. Marmots live in burrows; hibernate in winter, and have high reproductive rates. They are highly valued by humans for their meat and oil for food and their fur for garments. At the ecosystem level, their burrows provide unique habitat for plants and other wildlife. Marmots also have negative effects on human populations, as they are well documented as carriers of epidemic diseases, especially in areas around highly populated human settlements in Eurasia.

The first international symposium of marmot researchers was held in Italy (Aosta) in 1991. The second international conference was held in France (Aussois) in 1994. In August of 1997 the next international conference was held in Cheboksar city of Russia. The IV International Marmot Conference was organized in Switzerland (Montreaux) in September 2002. The International Bureau of Marmot Researchers initiated the V international conference in Tashkent, the capital city of Uzbekistan, in 2005 and the VI International conference was held again in Italy (Cogne, Valle d'Aosta) in 2008. Due to circumstances, the VII international conference, planned to be held in Slovakia, was canceled. Now, after a ten year interval, the VIIth International Marmot Conference will be held in Ulaanbaatar, the capital city of Mongolia. The conference was initiated and organized by the Institute of General & Experimental Biology of the Mongolian Academy of Sciences, the Ministry of Nature, Environment and Tourism of Mongolia, and the Marmot Commission of the Terralogical Society of the Russian Federation.

“Alpine Marmots”-The First International Symposium

The 1st International Symposium, with the theme “Alpine marmots (*Marmota marmota*) and the Genus *Marmota*” was held in Aosta, Italy on October 28-30, 1991. The main initiators and organizers were: the University of Turin, Grand Paradiso National Park, and the Centre for Applied Ecology. The proceedings were published in "The First International Symposium on Alpine Marmot (*Marmota marmota*) and on Genus *Marmota*: Proceedings, Saint Vincent, Aosta-Italy, October 28-30, 1991. 268 pp. хэвлүүлсэн. "and the editors were Bruno Bassano, Paolo Durio, Umberto Gallo Orsi, and Elisabetta Macchi.

It was decided that every three years an international forum of marmot researchers would be held.

The 2nd International Conference of Marmot Researchers (Aussois, France, 1994).

The Laboratory of Sociology of Claud Bernard University in France, initiated and organized the 2nd international conference on October 2-6, 1994 in Aussois.

Organizers invited 30 researchers from Central and Eastern Europe and Middle Asia. The conference was entitled "Marmots and people, marmots and health, and marmot biology". Twenty-nine oral presentations and 45 posters were discussed under these three main topics. During the conference, a round-table discussion on marmots and international legislation noted that the conservation status of this genus is very different in different countries due to its popularity as a hunting target in some countries.

Different research methods in some countries with marmots, as well as united management of data use and the establishment of an international marmot researchers' network were also discussed.

"Marmots of the Holarctic and Biodiversity Factors" III International Conference (1997, Cheboksar, Russian Federation)

At the Proceedings of the 3rd International Conference of Marmot Researchers held on August 25-30, 1997, representatives from nine countries, Belgium, Italy, Canada, Kazakhstan, Mongolia, the Russian Federation, the USA, Ukraine, and France, together produced more than 120 oral and poster presentations.

It was noted that since 1994, research activities on marmot biology, ecology, and conservation had widened, and the network of European marmot researchers had been established. The results of marmot theoretical and practical studies in Italy, Russia, Ukraine, and France, theoretical studies of marmots in the US and Kazakhstan, and the reintroduction work of scientists from Spain and France were acknowledged and highlighted

"Marmot Species Diversity" IV International Conference (2002, Montreaux, Switzerland)

The 4th international conference on marmots was initiated and organized by Claud Bernardt University, France, and the "Golden Pass Services" company in Montreaux of Switzerland on September 15-17, 2002.

"Marmot Species Diversity" V International Marmot Conference (Uzbekistan, Tashkent)

This conference on marmot species diversity was held in Tashkent, Uzbekistan from August 31-September 2. The conference was organized by the Institute of Zoology, the Uzbek Academy of Sciences and the Ugam-Chatgal Initiative. Twenty-five representatives from five countries, Great Britain, Italy, the Russian Federation, and Uzbekistan, attended the meeting. The conference discussed marmot conservation strategies and action plans, highlighted the importance of marmots at the ecological, economical, social, and cultural level in many countries, and also the importance of promoting international cooperation in scientific research and the conservation of the marmots.



"Marmot Species in a Changing World" VI International Conference (2008, Cogne, Valle d'Aosta, Italy).

The VI international conference was held from September 3-6 in the northern town of Cogne, in Italy.

The conference discussed the main oral and poster presentations and also organized a field trip to Gran Paradiso National Park to see the habitat of the Alpine marmots there. The proceedings of the meeting were published as a special issue in the *Ethology, Ecology, and Evolution* journal. During the conference, representatives from Slovakia suggested holding the next international conference in the city of Liptovský Mikuláš, Slovakia. The organizers started the registration and paper submission process and collected conference papers, however, due to the economical situation in their country, they asked to postpone the conference for one year and it was ultimately cancelled.

"Marmots of the Old and New World" VII International conference (2018, Ulaanbaatar, Mongolia).

The VII international conference under the theme 'Marmots of the Old and New World' will be held on August 13-17 in Ulaanbaatar, the capital city of Mongolia. More than 120 scientists from 13 countries, Mongolia, the Russian Federation, Austria, England, the USA, Germany, Italy, Kazakhstan, Kyrgyzstan, Ukraine, France, China, and Japan have already submitted the results of their studies, and 52 abstracts and 28 papers have been published in conference proceedings. We are currently in the process of completing the final stages of preparation and organization and are awaiting our guests.

Adiya Yansanjav (ScD)

Institute of General and Experimental Biology, MAS, Mongolia;

INTERNATIONAL CONFERENCE ON GENUS *MARMOTA*

Тарвага судлаачдын олон улсын хурлууд

Тарваганы зүйлүүд нь ЕвроАзи, Хойт Америкийн өргөн уудам нутагт тархсан биогеоценозын болон практикийн чухал ач холбогдолтой эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихээхэн татдаг өргөн цар хүрээтэй судлагддаг, өвөл ичээлдэг, нүхэнд амьдардаг, үржлийн чадавхи өндөр, амт чанар сайтай мах, өөх тосыг хүнсэнд, үслэг арьсыг хэрэглэдэг хөхтөн юм. Тарваганы зүйлүүдийн нөлөөгөөр олон зүйл амьтан, ургамлын амьдрах, ургах орчин нөхцөл бүрэлдэн бий болдог онцлогтой. Тарваганы зүйлийг өргөн цар хүрээтэй судалсаны нэг шалтгаан нь хүн ам шигүү суурьшсан ЕврАзийн бүс нутагт байгалийн голомтот халдварт өвчний нян тээгч үндсэн агуулагч байгаатай холбоотой.

Тарвага судлаачдын анхны олон улсын хурал 1991 онд Итали (Aosta)-д, II хуралдаан 1994 онд Францид (Aussois). 1997 оны 8-р сард тарвага судлаачдын олон улсын эрдэм шинжилгээний бага хурал ОХУ-ын Чебоксар хотод, IV хуралдаан 2002 оны 9-р сард Швейцарийн Монтрё-д зохион байгуулагджээ. 2005 онд тарвага судлаачдын Олон улсын товчооны санаачлагаар V бага хурлыг Узбекистан улсын нийслэл Ташкент хотноо, сүүлчийн VI бага хурлыг 2008 онд 2 дахь удаагаа Италид (Cogne, Valle d'Aosta) зохион байгуулсан. Олон улсын ээлжит VII бага хурлыг Словак улсад зохион байгуулахаар төлөвлөсөн ч тодорхой шалтгааны улмаас цуцлагдаж, 10 жил завсарласны дараа Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод 2018 оны VIII сард ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, Байгаль орчин аялал жуулчлалын яам, ОХУ-ын Хөхтний нийгэмлэгийн Тарваганы комиссын санаачлагаар зохион байгуулж байна.

Альпийн тарвага сэдэвт Олон улсын анхдугаар Симпозиум

Альпийн тарвага (*Marmota marmota*) ба Тарваганы төрөл *Marmota* Олон улсын анхдугаар Симпозиум Италийн Аоста хотод 1991 оны 10 сарын 28-30-нд зохион байгуулагджээ.

Зохион байгуулагчид: Туринскийн их сургууль, Гран Парадизогийн үндэсний парк, Экологийн хавсарга судалгааны төв уг хурлыг санаачлан зохион байгуулсан. Симпозиумын материалыг-"First International Symposium on Alpine Marmot (*Marmota marmota*) and on Genus *Marmota*: Proceedings, Saint Vincent, Aosta-Italy, October 28-30, 1991. 268 pp. хэвлүүлсэн. " Редактор: Bruno Bassano, Paolo Durio, Umberto Gallo Orsi, Elisabetta Macchi.

Олон улсын тарвага судлаачдын бага хурлыг 3 жилд нэг удаа зохион байгуулахаар шийдвэрлэжээ.

Тарвага судлаачдын Олон улсын II бага хурал (1994, Францын Оссеа).

Олон улсын тарвага судлаачдын хоёрдугаар бага хурал Францын Оссеа хотод Клода Бернардын Их сургуулийн социологийн лабораторийн санаачлагаар 1994 оны 10-р сарын 2-6-ны өдрүүдэд зохион байгуулагджээ.



Дэлхийн тарвага бүхий олон улс оронд хийгдэж буй судалгааны ажлын арга зүй, мэдээллийн ашиглалтыг нэгдсэн удирдлагаар хангах, Олон улсын тарвага судлаачдын сүлжээ бий болгох талаар хэлэлцжээ.

Тарвага судлаачдын 1997 оны 8 сарын 25-30-нд зохион байгуулагдсан Олон улсын III бага хуралд Бельги, Итали, Канад, Казахстан, Монгол, ОХУ, АНУ, Украин, Франц зэрэг дэлхийн 9 орны төлөөлөгчид оролцож, Австри, Испани, Узбекистан, Японы эрдэмтэд судалгааны ажлын үр дүнг илтгэсэн материалаа ирүүлж нийт 120 гаруй илтгэл, хураангуйг нэгтгэсэн бүтээлийг хэвлүүлжээ.

1994 оноос тарваганы биологи экологи, хамгаалал, популяцийг нөхөн сэргээх зэрэг олон асуудлаар дэлхийн улс орнуудын судлаачдын үйл ажиллагаа идэвхжиж, тарвага судлалын Европын сүлжээ байгуулагдаж, Итали, Орос, Украин, Францын судлаачдын тарвага судлалын онол, практик үр дүн, АНУ, Казахстаны эрдэмтдийн онолын судалгааны ажлын дүн, Испани, Францын эрдэмтдийн тарваганы популяцийг сэргээсэн туршилт судалгааны ажлын үр дүнг өндрөөр үнэлжээ.

Францын Клода Бернардын Их сургууль, "Golden Pass Services" компанийн санаачлага, санхүүгийн дэмжлэгээр Швейцарийн Монтрёд Тарвага судлаачдын Олон улсын "Тарваганы төрөл зүйл" сэдэвт IY бага хурлыг 2002 оны 9 сарын 15-17-нд зохион байгуулжээ.

Тарваганы төрөл зүйл Олон улсын Y бага хурлыг Узбекистаны Ташкент хотод 2005 оны 8 сарын 31-ээс 9 сарын 2-ны хугацаанд зохион байгуулжээ. Хурлыг Узбекистаны Шинжлэх ухааны академийн Амьтны хүрээлэн, Угам-Чаткаль, Чаткалийн санаачлага санхүүгийн дэмжлэгээр зохион байгуулж, Их Британи, Итали, ОХУ, Франц, Узбекистан хэмээх 5 улсын 25 судлаачид оролцжээ. Бага хурал тарвага хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө стратегийг хэлэлцэж, олон улс оронд биогеоценоз, эдийн засаг, соёл нийгмийн чухал ач холбогдолтойг үнэлж, тарваганы биологи экологи онцлогийг судлах, хамгаалахад олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэжээ.

"Өөрчлөгдөн буй ертөнцийн Тарваганы төрөл зүйл" сэдэвт Олон улсын YI бага хурал (2008,Cogne, Valle d'Aosta,Italy).

Тарвага судлаачдын Олон улсын " Өөрчлөгдөн буй ертөнцийн Тарваганы төрөл зүйл" сэдэвт YI бага хурал 2008 оны 9 сарын 3-6-нд Италийн хойд бүс нутгийн Конье хотхонд зохион байгуулагджээ.

Бага хурал үндсэн илтгэл, ханын илтгэлийн хэлэлцүүлэг хийж, Gran Paradiso Байгалийн цогцолборт газарт альп тарваганы байршил нутагтай танилцах аялалыг зохион байгуулсан байна. Хурлын илтгэлийг Ethology Ecology and Evolution сэтгүүлд тусгай дугаар болгон хэвлүүлсэн. Олон улсын YI хуралдааныг зохион байгуулах явцад Словакийн мэргэжилтнүүд өөрийн улсын Liptovský Mikuláš хотод 2011 онд YII бага хурлыг зохион байгуулах санаачлагыг гаргаж, оролцогсдыг бүртгэх, хурлын илтгэл материалыг хүлээн авах ажлыг зохион байгуулсан боловч улс орны эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан нэг жилээр хойшлуулж, дараа нь бүрмөсөн цуцалсан юм.

"Дэлхийн тарваганы зүйлүүд" Олон улсын YII бага хурал (2018, Монгол улс, Улаанбаатар).

Тарвага судлаачдын 'Marmots of Old and New World сэдэвт 2018 оны 8 сарын 13-17-нд зохион байгуулах Олон улсын YII бага хуралд Монгол, ОХУ, Австри, Англи, АНУ, ХБНГУ, Итали, Казахстан, Киргиз, Украин, Франц, БНХАУ, Япон хэмээх дэлхийн 13 орны 120 гаруй эрдэмтэн судлаачид судалгааны ажлын үр дүнг илтгэсэн материалаа ирүүлж, 52 илтгэлийн хураангуй, 28 илтгэлийг бүрэн эхээр нь нэгтгэсэн бүтээлийг хэвлүүлж, хурлыг амжилттай зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган зочид, төлөөлөгчдөө хүлээн авахад бэлтгэж байна.

Биологийн шинжлэх ухааны доктор

Я.Адъяа